



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-44-44, Факс: (976-11) 32-90-84,  
E-mail: [info@frc.mn](mailto:info@frc.mn), <http://www.frc.mn>

2022.07.06 № ЦАТ-11/03/018

танай 2022.06.06, 06.29 -ны № 4<sup>з</sup>, 9/4  
-Т

Агентын өөрчлөлтийг бүртгэсэн тухай

Танай компаниас 2022 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн 4<sup>з</sup> тоот, 6 дугаар сарын 29-ний өдрийн 9/4 тоот албан бичгээр болон “Зөвшөөрлийн цахим систем”-ээр ирүүлсэн агентын өөрчлөлтийг бүртгүүлэх тухай хүсэлтийг Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 120 дугаар тогтоолоор баталсан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам”-ын дагуу хянаж үзлээ.

Дээрх журмын 6.7-д “Хороо үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагаас ирүүлсэн эрх бүхий албан тушаалтан болон брокер, агентын өөрчлөлтийг бүртгүүлэх хүсэлтийн дагуу бүртгэл хийж, хариуг албан бичгээр мэдэгдэнэ” гэж заасны дагуу агент Төмөрбаатарын Ганзориг, Пүрэвдоржийн Дэчин нарыг бүртгэлээс хасаж, Зундуйдоржийн Сэвжидмаа, Жаргалсайханы Хуягбаатар нарын 2 агентыг Хорооны нэгдсэн бүртгэлд бүртгэж, өөрчлөлтийг хийсэн болохыг мэдэгдье.



